



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/493

Эрдэнэт

Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд  
оролцох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/a/, 29.1.5/a/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.1, 8.1.3, 8.1.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Үндэсний спортын VI их наадмыг зохион байгуулах тухай” 269 дүгээр тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын тогтоолоор 2018 оны 08 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд аймгийн баг бүрэлдэхүүн оролцоход 15300450 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тэмцээнд шаардагдах 15300450 /Арван таван сая гурван зуун мянга дөрвөн зуун тавин/ төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлын “Үндэсний спортын IV их наадмыг зохион байгуулах арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулахыг Ажлын хэсэг /н.Түвшинжаргал/, Биеийн тамир спортын газар /н.Зулбаатар/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ